


МОНГОЛЫН
ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



2014 ОН:
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





ГАРЧИГ

- БИД ХЭН БЭ?
- МОНГОЛ ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ
- МОНГОЛ УЛСЫГ ШУДАРГААР ШҮҮХИЙГ УРИАЛЖ БАЙНА
- ХҮНИЙГ ХҮНДЭЛ КАМПАНИТ АЖИЛ
- ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ КАМПАНИТ АЖИЛ
- ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮМҮҮС
- ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КАМПАНИТ АЖИЛ
- ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ
- БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ - ЗАЛУУЧУУД ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ
- САНХҮҮГИЙН ТАЙЛАН
- ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД
- 2014 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ


БИД ХЭН БЭ

Эмнэсти Интернэшнл нь хүний эрхийн төлөөх хүмүүсийн дэлхий дахинь хөдөлгөөн юм. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид.


Манай ЭРХЭМ зорилго

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрхийг энэ дэлхийн хүн бүрт эдлүүлэхэд оршино.

Эмнэсти Интернэшнл 150 гаруй улс орон, газар нутагт 7 сая гишүүд дэмжигчидтэй. Монголын Эмнэсти Интернэшнл мэргэжил, сонирхолоороо нэгдсэн 3632 гишүүд, дэмжигчидтэй



Гишүүдийн өсөлт



УДИРДАХ ЗӨВЛӨЛ



С.Ганчимэг
Удирдах зөвлөлийн
дарга



А.Түвшинтула
Удирдах Зөвлөлийн
дэд дарга



Ш.Анхмаа
Санхүүч, Удирдах
зөвлөлийн гишүүн



Л.Нэргүй
Бүлэг гишүүд
хариуцсан гишүүн



Д.Оюунсүрэн
Хэвлэл мэдээлэл
хариуцсан гишүүн



Б.Болорсайхан
Хүний Эрхийн
Боловсрол
хариуцсан гишүүн



М.Чинзориг
Кампанит ажил
хариуцсан гишүүн



М.Буянхишиг
Залуучууд
хариуцсан гишүүн



Я.Мөнхчимэг
Кампанит ажил
хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



Б.Мөнхжавхлан
Хяналтын
зөвлөлийн дарга



С.Очирбат
Хяналтын
зөвлөлийн гишүүн



М.Адъяаням
Хяналтын
зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



МОНГОЛЫН
ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

ХУНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ
20 ЖИЛ



Б.Алтантуяа
Гүйцэтгэх захирагч



Г.Амарзаяа
Кампанит ажил
хариуцсан зохицуулагч



П.Мөнхжаргал
ХЭБ, кампанит ажил
хариуцсан зохицуулагч



Д.Ариунбулаган
Санхүүгийн
ажилтан



Б.Аззаяа
Хөгжил, гишүүнчлэл
хариуцсан зохицуулагч



Э.Мөнхдэмбэрэл
Сан арвижуулагч

САЙН ДУРЫН АЖИЛТНУУД

Хүний эрхийн төлөөх үйлсэд сайн дурынхны мэдлэг, ур чадвар, тун чухал тул 2014 МЭИ-д онд гэрээний дагуу 35 сайн дурын ажилтан ажиллаж, Отгон тэнгэр их сургууль, МУИС-НШУС-Хүмүүнлэгийн сургуулийн оюутнууд мэргэжлийн дадлага хийлээ.



Э.Анударь



Б.Батчимэг



Э.Мөнхбаяр



Мягмарсүрэн



М.Мөнхсуурь



Б.Хоролсүрэн



Чанцалдулам



Б.Мандал



А.Жанболат



Б.Сумьяа



Э.Төгөлдөр



Ц.Цэнгүүн



Г.Гантуул



Л.Саруулбаяр



С.Бямбасайхан

МОНГОЛ ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ 2014 ОН

МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: Цахиагийн Элбэгдорж
Засгийн газрын тэргүүн: Чимэдийн Сайханбилэг

Цагдан саатуулах газарт эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа өргөн тархсан. Хотод албадан нүүлгэсээр байна. Хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, жендэрт сууринласан алагчлалыг огт тоохгүй хэвээр байна.
"Non-refoulement" зарчмыг зөрчин орогнол эрэгчдийг хүний эрхийн ноцтой зөрчилд өртөх эрсдэлтэй улсад албадан буцаажээ.

Үндсэн мэдээлэл

Монгол улс 10-р сард Хүчээр алга болгохоос бүх хүмүүсийг хамгаалах тухай олон улсын конвенцийг соёрхон батлав. Гэвч 2012 онд соёрхон баталсан ИУТЭОУП-ын цаазаар авах ялыг халах тухай 2-р Нэмэлт Протоколын дагуу үндэсний хууль тогтоомждоо өөрчлөлт оруулаагүй байна.

Эрүүдэн шүүх болон зүй бус харьцаа
Эрүү шүүлт болон зүй бус харьцааг ялангуяа "хэрэг хүлээлгэх"-ийн тулд хэрэглэх нь хүний эрхийн ноцтой асуудал хэвээр байна. Хорих, цагдан хорижод баривчлагдсан хүмүүсийг эрүүдэн шүүж, зүй бус харьцсан хэрэгт сэжиглэгдсэн цагдаа, хорихын хянагч нарыг үр дүнтэй мөрдөн шалгаагүй ба хариуцлага тооцоогүй байна.

Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн Байцаах Алба 1-р сард татан буугдсан. Уг Мөрдөн Байцаах Алба нь байцаалтын явцад хүчээр мэдүүлэг авсан гэх цагдаа, прокурор, шүүгчийн эсрэг гомдлыг мөрдөн шалгах үүрэгтэй байсан. Гэтэл Монгол улсад эрүүдэн шүүх болон зүй бус харьцсан хэргүүдийг цагдаагийн байгууллага шалгах болсон нь ийм төрлийн хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах хараат бус механизм дутагдаж байгааг харууллаа.

2-р сард Архангай аймгийн цагдан хорих төвд хоригдож байхад нь хэрэг хүлээлгэхийн тулд цахилгаан бороохойгоор цохиулж, зодсон хэмээн гурван иргэн Монголын Хүний Эрхийн Үндэсний Комисст гомдол гаргажээ. Тэдний нэг нь хэрэг хүлээлгэхийн тулд хүч хэрэглэж, б хоног

хоолгүй хорьсон хэмээн мэдүүлжээ. УЕПДМБА нь татан буугдсан тул Архангай аймгийн цагдаагийн хэлтэс энэ хэргийг мөрдөн шалгасан. Улмаар эрүүдэн шүүж, хэрцгий, хүнлэг бусаар харьцсан талаарх гомдлыг хэрэгсэхгүй болгожээ.

Орон байртай байх эрх - Албадан нүүлгэлт

Улаанбаатар хотын гэр хорооллын иргэд шаардлага хангасан орон байр, цэвэр ус, эрүүл ахуйн нөхцөл зэрэг үндсэн үйлчилгээгээр хангагдаж чадахгүй байна. Улаанбаатар хотын 7-р бичил хорооллын зарим иргэдтэй зөвлөлдөж, эсхүл хууль зүйн хамгаалалт, баталгаа өгөлгүйгээр 2007 онд орон гэрээс нь албадан нүүлгэсэн ч, амласан орон сууцаа олгоогүй байна.

Ялгаварлан гадуурхалт

Үндэс угсаа, жендэр, бэлгийн чиг баримжаа болон хөгжлийн бэрхшээлд сууринласан ялгаварлан гадуурхалт байсаар байна. Үндэсний цөөнх болон хөдөө, орон нутагт амьдардаг ядуу, нийгмээс гадуурхагдсан эмэгтэйчүүдийг алагчлан үзэх жендэрийн ялгаварлал байна. Лесбиян, гей, бисексуал, трансжендэр болон интерсекс хүмүүсийн эсрэг халдлага, дайралт, ялгаварлан гадуурхалт байсаар байна. Хуулиндаа бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй эрэгтэй хүн болон хөвгүүнийг хохирогч гэж тодорхойлоогүйгээс эрэгтэй хохирогчдод шаардлагатай эмчилгээ сувилгаа, нөхөн олговор авах, шүүхэд хандах, гомдлоо барагдуулахад нь бэрхшээл тулгарч байна.

Дүрвэгсэд ба орогнол эрэгчид

2014 оны 5-р сард Өвөр Монголын Өөртөө Засах Орны хоёр орогнол эрэгчийг БНХАУ-руу албадан буцаажээ. Тухайн үед НҮБ-ын Дүрвэгсэдийн асуудал эрхэлсэн Дээд комиссырын газраас тэдний нэгэнд дүрвэгчийн статус өгөхөөр шалгаж байсан ч статус тодорхойлох процесс дуусаагүй байхад "non-refoulement" зарчмыг зөрчин албадан гаргаж, хүний эрхийн ноцтой зөрчилд өртөх эрсдэлтэй улсад шилжүүлэн өгчээ.

МОНГОЛ УЛСЫГ ШУДАРГААР ШҮҮХИЙГ УРИАЛЖ БАЙНА

Эмнэсти Интернэшнл олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Монголын эрх баригчдад хандан нэн даруй шударга шүүхийн зарчмыг хүндэтгэхийг уриалж байна. Монгол улсын эрүүгийн шүүхийн тогтолцоо олон улсын хууль, хэм хэмжээтэй нийцэж байгааг яаралтай баталгаажуулахгүй бол олон хувь хүн эрсдэлд ороод байна.

Эмнэсти Интернэшнл байгууллага өнгөрсөн хугацаанд олон улсын хуулийг илтэд зөрчин "хэрэг хүлээлгэхийн тулд" эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бус харьцсан тухай хэргийг баримтжуулж авсан. Монгол улсын нэгдэн орсон олон улсын хуулиуд болох Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүnlэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг НҮБ-ын Конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт(ИУТЭОУП)-аар эрүүдэн шүүх буюу бусад зүй бус харьцааны аливаа хэлбэрийг туйлын байдлаар бүх нөхцөлд хориглодог. Мөн ИУТЭОУП-д шударгаар шүүх наад захын шаардлагуудыг тусгасан байдаг.

Конвенцийг тайлбарлах үүрэг бүхий НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо 2011 онд Монгол улсын эрх баригч наарт хандан "саатуулах байранд эрүүдэн шүүж, хэрцгий харьцаж хэрэг хүлээлгэсэн мэдүүлгийг хэрэгтний эсрэг нотлох баримт хэмээн хүлээн зөвшөөрөх ёсгүй баталгаажуулах"-ыг зөвлөмжилсөн.¹ Гэвч Монголын эрүүгийн шүүхийн тогтолцоог хэрэг хүлээлгэхдээ гэм буруутай тухай мэдүүлэг авахыг илүү чухалчилдаг гэж үздэг.²

Эрүүдэн шүүж, зүй бус харьцаж, албадлагын бусад хэлбэр хэрэглэн авсан мэдүүлгийг эрүүгийн шүүх тогтолцоонд эрүүдэн шүүгчийн эсрэг биш л бол нотлох баримтаар хэрэглэхгүй байх ёстай. Хууль бусаар олж авсан нотлох баримтыг хэлэлцэхгүй байх дүрэм нь эрүүдэн шүүх, бусад хэрцгий харьцахыг хориглох, мөн тэрчлэн буруутгагдаж байгаа хүмүүст өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, дуугүй байх эрхийг нь хангах салшгүй хэсэг юм. Эдгээр эрхийг хүндэтгэхийн тулд эрүүдэн шүүж, зүй бус харьцаж, эсвэл албадлага, дарамт шахалт үзүүлж авсан нотлох баримтанд түшиглэлгүйгээр яллах ажиллагаа хэргийг нотлохыг шаарддаг.

Эмнэсти Интернэшнл мөн дур зоргоор баривчилан, хорьж байгаа практик үргэлжилж байгаад санаа зовниж байна. Хуульчид болон өмнө нь хоригдож байсан хүмүүсийн хамаатнуудын хэлснээр баривчлагдсан сэжигтнүүд өмгөөлөгчтэйгөө яаралтай холбогдож чаддаггүй байна. Монгол улсын үндэсний хууль болон олон улсын хуулиуд дур зоргоор баривчилан хорихыг хориглодог. Мөн ИУТЭОУП нь эрх чөлөөгөө хасуулсан бүх хүмүүстэй хүnlэг харьцаж, нэр төрийг нь хүндэтгэх ёстай хэмээн шаарддаг.

Эрүүгийн шүүн таслах тогтолцоо нь эрүүгийн хэрэг үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэхийг баталгаажуулахдаа мөн сэжигтний эрхийг хангаж, хүндэтгэх ч ёстай. Үнд гэм буруутай нь хуулиар нотлогдтол гэм буруугүй тооцогдох эрх багтдаг. Энэ эрх нь хэрэг бүртгэхийн өмнөөс эхлээд ял шийтгэл нь эцсийн шатны шүүхээр батлагдах хүртэл аливаа сэжигтэнд хамаарна. Энэ нь эрх баригчид, үүний дотор прокурор, цагдаа, төрийн албан тушаалтан буруутгагдаж байгаа аливаа этгээдийн гэм буруутай эсэх талаарх өөрийн санаа бодлыг тусгасан мэдэгдлийг эрүүгийн шүүх ажиллагааны дүгнэлтээс өмнө хийх ёсгүй гэсэн үг. Энэ бол гэм буруугүй байх зарчимтай нийцүүлэн шүүгдэж байгаа бүх хүнтэй хүnlэг харьцаж, нэр төрийг нь хүндэтгэхийг баталгаажуулах Монголын эрх баригчдын үүрэг юм.

Тиймээс олон улсын хүний эрхийн энэ өдрийг тохиолдуулан Эмнэсти Интернэшнлээс Монголын эрх баригч наарт хандан дараах уриалгыг хүргүүлж байна.

- Эрүүдэн шүүж, хэрцгий харьцаж, албадлагын бусад хэлбэр хэрэглэн авсан мэдүүлгийг эрүүдэн шүүсэн гэдгийг нотлоход биш л бол эрүүгийн шүүх ажиллагаанд нотлох баримтаар хэрэглэхгүй байхыг баталгаажуулах
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүnlэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудлаарх НҮБ-ын Тусгай Илтгэгч, Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо зэрэг шинжээчдийн эрүүдэн шүүх болон хэрцгий харьцаж, шийтгэхээс урьдчилан сэргийлэх асуудлаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх яаралтай алхамыг хийх
- Зүй бус харьцсан, дур зоргоор баривчилж, хорьсон тухай мэдээллийг яаралтай, шударгаар, хараат бусаар, ил тодоор мөрдөн шалгахыг баталгаажуулах, сэжигтэн, хоригдож байгаа хүмүүсийн эрхийг зөрчсөн хууль сахиулах ажилтнуудад хариуцлага тооцох, шаардлагатай бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг баталгаажуулах
- Хоригдож байгаа бүх хүн өөрсдийн сонгосон өмгөөлөгчтэйгөө хувийн нууцлал хангасан нөхцөлд яаралтай, тогтмол уулзах, хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай бол зохих эмнэлгийн тусламж үзүүлэх, мөн гэр булийн гишүүдтэйгээ харилцаа холбоотой, уулзах боломжтой байхыг яаралтай баталгаажуулах

(Endnotes)

¹ CAT, Concluding Observations: Mongolia, UN Doc. CAT/C/MNG/CO/1 (2010) §18.

² See already Special Rapporteur on torture, UN Doc. E/CN.4/2006/6/Add.4, §36.

(((хүнийг хүндэл)))



Зорилго, зорилтууд:

- Ядуусын дуу хоолойг сонсгож, эрх чөлөө, нээлттэй ил тод байдал, эвлэлдэн нэгдэх эрх, мэдээ мэдээллээр хангах
- Эрхээ мэдэж, нэхэмжлэх замаар ядуу нэхцэлд амьдарч буй иргэдийг чадавхижуулах
- Төр, терийн бус оролцогчдыг хариуцлагатай болгох

Эхийн эрүүл мэнд ба бэлгийн болон нэхэн үржихүйн эрхийн төлөөх үйл ажиллагаа

■ Эмнести Интернэшнлээс дэлхийн 1,9 тэрбум залуу хүнд тулгамдаад байгаа бэлгийн болон нэхэн үржихүйн эрх бол хүний үндсэн эрх бөгөөд тэр дундаа залуус өөрсдийн амьдрал, бие махбодтой холбоотой шийдвэрийг өөрсдөө гаргах эрхтэй хэмээн Миний бие миний эрх /МБМЭ/ кампанит ажлыг эхлүүлсэн юм.

■ МЭИ-ийн гишүүд "Миний бие, Миний эрх" кампанит ажлын талаар Royal HD телевизийн Баасан гарагийн шууд нэвтрүүлгээр 2 удаа мэдээлэл хийж, хүчирхийллийн эсрэг дуу хоолойгоо өргөхөд залуучуудыг нэгдэхийг уриаллаа.

■ Хүчингийн хэрэг, хүчирхийллийн эсрэг өөрийн дуу хоолойгоо урлагаар илэрхийлэх, урлагаар дамжуулан хүмүүст эрхийг нь таниулах уриалга бүхий ил захидалыг урлагийнхан болон Монгол Улсын Соёл Урлагын их сургуулийн оюутан нийт 500 хүнд хүргэлээ.

■ Нэхэн үржихүйн эрхийн талаар сургалт явуулах хүний эрхийн 20 сургагч багш бэлтгэн, Налайх дүүргийн 119-р сургууль, 107, 86, Хүрээ тулга сургууль, Орхон аймгийн Эрдэм ахлах сургууль болон Дархан-Уул аймгийн Од цогцолбор сургуулийн 250 гаруй сургачид, багш нарт сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагаа зохион байгууллаа.

■ Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон бусад ТББ-тай хамтран "Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аян"-ны хүрээнд Налайх дүүргийн иргэд,





багш, сургачид, түүнчлэн Хөдөө аж ахуйн их сургууль /ХААИС/-ийн багш, оюутнууд, нийт 300 гаруй хүнд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль, МБМЭ кампанит ажил, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн тухай танилцуулав.

- Эль Сальвадор, Магребын орнууд, болон Афганистан улсын хэрэг дээр өв санааны нэгдлээ илэрхийлэн www.amnesty.mn сайтад гарын үсэг цуглуулах цахим үйл ажиллагаа өрнүүлж, нийт 1018 захиаг холбогдох орны эрх баригчдад илгээв.
- Хүний эрхийн төлөөх залуусын дуу хоолойг хүргэх "Нээлттэй өдөр" үйл ажиллагааг Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газартай хамтран зохион байгуулж, 100 байгууллагын 5000 гаруй иргэн болон Шихихутг Хууль зүйн сургуулийн 90 оюутанд бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаарх мэдээлэл, сурталчилгааны материал тараалаа.

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн баталгаа: Албадан нүүлгэхээс ангид байх эрх

- Газар эзэмших, өмчлөх тухай асуудал нь Монгол оронд тулгамдаж буй асуудлын нэг болоод байна. Хот дахин төлөвлөх тухай хуулийн хүрээнд "Гэр хорооллыг дахин төлөвлөх төсөл" хэрэгжиж буйтай холбоотой хүний эрхийг зөрчих явдал гарсаар байна.
- Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөлд Эмнести Интернэшнлээс зөвлөмж хүргүүллээ.
- "Хүний эрх ба албадан нүүлгэлт" тараах материалыг МЭИ-ийн цахим хуудас, Фейсбуук, Зууны мэдээ, Монголын мэдээ, mminfo.mn сайтаар дамжуулан олон нийтэд хүргэв.
- Эмнести Интернэшнлийн Зүүн Азийн бүсийн төвийн Судалгааны хэлтсийн захирал

Розанн Райф, судлаач Хирока Шожи нар Монголд айлчилж, газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах, нөхөн олговор олгох болон газрын тухай багц хуулийн төсөл олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх талаар иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй уулzan санал бодлыг нь сонсов.

- НҮБ-ын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт газар албадан чөлөөлөлтөд өртөн хохирсон иргэдийн асуудлыг тусгасан илтгэлийг шинэчлэн хүргэлээ.

Амжилт, үр дүн, үр нөлөө:

- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хамгаалах, чанартай боловсролын асуудлаар 6090 хүнд мэдээлэл өгөв.
- 1000 гаруй цахим захидалыг Эль Сальвадор, Магребийн орнууд болон Афганистан улсын эрх баригч наарт илгээлээ.
- Нөхөн үржихүйн эрх, хүчирхийллээс ангид байх эрхийн төлөө дугардаг, үйл ажиллагаа явуулдаг идэвхитэн дэмжигчдийн хүрээ тэлж, залуус хүчингийн гэмт хэрэг, хүчирхийллийн эсрэг дуу хоолой өргөх нь нэмэгдэв.
- Газар өмчлөх эрх, газар чөлөөлөлт, албадан нүүлгэх асуудал олон нийт болон хэвлэл мэдээлэл, хууль тогтоогч нарын анхаарлын төвд байв.
- Үйл ажиллагааг 5812 дэмжигч цахимаар дэмжсэн.



ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ



Зорилго, зорилтууд:

- Монгол улсад цаазаар авах ялыг хуульдаа халахад нөлөөлөх
- Үр дүн нь хүний эрхэд чиглэсэн, харилцан ашигтай харилцааг бусадтай тогтоох
- Улс орондоо явуулж буй ажлыг дэлхий нийтийг хамарсан зорилтуудтай нийцүүлэн явуулах;
- Үйл ажиллагаанд гишүүд дэмжигчдийг өргөнөөр оролцуулах

Нөлөөлөл

■ Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран НҮБ-ын Ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн асуудлаар ГХЯ, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, УИХ дахь Ардчилсан нам, МА-ын нам, Шударга ёс эвсэл, УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, ХЗЯ-тай удирдлагуудтай уулзалт хийв. ИУТЭОУП-ын Нэмэлт II Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, Монгол улсад энэ ялыг бүрэн халахын тулд Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг хасах тухай хуулийн төсөл санаачилахыг Ерөнхийлөгчид уриалав. Цаазаар авах ялыг зогсоо Тайванийн нийгэмлэгтэй хамтран Монгол улсад цаазаар авах ялыг халах үйл явцыг сурвалжлах уулзалтууд зохион байгууллаа.

■ 2014 оны 9 сард Олон улсын төвийн болон бус нутгийн хүний эрхийн шинжээч нартай хамтран НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэгт шинэчилсэн илтгэл хүргүүлж, Монгол, Англи хэл дээр amnesty.mn, mminfo.mn, vip76.mn сайтын болон Монголын мэдээ сониноор дамжуулан нийтийн хүртэл болгов.

Олон улсын кампанит ажил

■ 2014 оны 10-р сарын 10 буюу Цаазаар авах ялын эсрэг Дэлхийн өдрөөр Эмнэсти Интернэшнл болон Цаазаар авах ялын эсрэг Дэлхийн Эвслээс улс орнууд олон улсын хэм хэмжээг зөрчин сэтгэцийн өвчтэй, оюуны хомсдолтой хүмүүст ялын дээд хэмжээг хэрэглэж байгаа асуудлыг олны анхааралд хүргэлээ. Кино хэлэлцүүлгээр дамжуулан олон нийт, зорилтот бүлэгт зөв мэдээллийг түгээх зорилгоор энэ өдрийг тохиолдуулан "Дэвид Гейлийн амьдрал", "Үхдэл явж байна" киноор МУИС-ийн ХЗС, ШУС, Отгонтэнгэр, Цэцээ гүн, Улаанбаатар их сургуулийн оюутнууд, мөн Төв аймгийн иргэдэд кино хэлэлцүүлэг зохион байгуулж, дэлхийн чиг хандлагыг таниулаа. Хэлэлцүүлэг 450 гаруй хүн хамарч, Япон улсад цаазаар авах ялыг халахыг уриалсан захидалд гарын үсэг цуглуулж илгээлээ.

■ Тайваньд болсон цаазаар авах ялыг халах талаарх олон улсын хурал болон Цаазаар авах ялыг халах Азийн сүлжээний хуралд оролцож "Монгол улс дахь цаазаар авах ялын өнөөгийн байдал" сэдвээр илтгэл тавьлаа.





Хэвлэл, мэдээлэл, соён гэгээрүүлэх

■ Дэлхийн улс орнуудын 2013 онд цаазаар авах ялыг халсан болон хэрэглэсэн талаарх тоо баримт бүхий “Цаазаар авах ял ба гүйцэтгэл-2013” тайланг териин холбогдох албан тушаалтан, ТББ, иргэний нийгмийн байгууллагууд, хувь хүмүүст хүргэв. Уг тайланг олон нийтэд хүргэх зорилгоор ХСИС, Орхон ХЗС, МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль, мөн Дархан-Уул аймгийн ШУТИС-ын оюутнуудад “Хүний эрх ба цаазаар авах ял” хэлэлцүүлэгт зохион байгуулав. Цаазаар авах ялын талаарх мэдээ, мэдээллийг өдөр тутмын сонин, МЭИ-ийн сайт, бусад сайтуудаар олон нийтэд хүргэлээ.

Амжилт, үр дүн:

- Цаазаар авах ялын эсрэг Азийн сүлжээний удирдах зөвлөлд сонгогдов.
- Цаазаар авах ялыг халах дэлхийн чиг хандлагын талаарх хэлэлцүүлэгт 500 гаруй хүн оролцож, мэдээ мэдээлэл 10000 орчим хүнд хүрлээ.
- Цаазаар авах ялын асуудлаарх мэдээ, нийтлэлүүд өдөр тутмын сонин хэвлэл, цахим хуудас, телевизийн анхаарлын төвд байж, олон нийтэд хүрэв

ЭРСДЭЛД БҮЙ ХУВЬ ХҮМҮҮС



Зорилго, зорилтууд:

- Эрсдэлд буй хувь хүн, хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх,
- Хамтран ажиллах байгууллагын хүрээг тэлэх
- Үйл ажиллагаанд гишүүд дэмжигчдийг өргөнөөр оролцуулах

Яаралтай үйл ажиллагаа

- Хятад, Украян, Тайланд улсад эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн хэрэг дээр цахим үйл ажиллагаа өрнүүлэв.



Нэлөөлөл

- Гадаадын иргэдийг хууль бусаар албадан гаргаж болзошгүй байгаа асуудлаар Хууль зүйн сайд, хувийг Гадаадын иргэн харьяатын албаны даргад хүргүүлэв. Солонгос улсыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Израйль, Палестины зэвсэгт бүлэглэлд зэвсэг нийлүүлэхийг хориглосон хориглолтыг баталгаажуулахад тусалж, Израйль руу зэвсэг нийлүүлэхээ зогсоох, ЗХГ-г соёрхон батлахыг уриалсан албан захидалыг Өмнөд Солонгосын элчин сайдад хүргүүлэв.

- Гонконгийн бүсийн төвийн Зүүн Азийг хариуцсан Судалгааны багийн захирал Розанн, судлаач Хирока нар Монголд айлчилж НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэгт хүргүүлэх тайлан, ЭИ-ийн тайлангийн



асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүстэй уулзалт хийв.

Захидал Уриалгын Марафон

■ 12-р сарын 10 буюу Олон улсын Хүний Эрхийн өдрийг тохиолдуулан Захидал Уриалгын Марафоныг МУИС-ийн ШУС, ОУХС, ШУТИС-ийн оюутнуудад, ЕБ-ийн 33, 118, 51, 107-р сургуулиуд болон Монген, Төгс дэлгэрэх сургуулийн сурагчдад, Чингэлтэй дүүргийн иргэд, Тэди бизнес төв, Хороолын Номин их дэлгүүрт олон нийтэд мөн Дархан, Эрдэнэтийн бүлгийн гишүүд орон нутагтаа зохион байгууллаа.

■ Эрхийнхээ төлөө бичицгээе аянаар Филиппин, АНУ, Өмнөд Африк, Энэтхэгийн хувь хүмүүсийн хэрэг дээр цахим бусаар гарын үсэг цуглуулж, Узбекистан, Норвеги, Арабын Нэгдсэн Эмират, Хятадын эрх баригч нарт илгээв.

хүний хэрэг дээр www.amnesty.mn сайтад цахим үйл ажиллагаа зохион байгууллаа.

Амжилт, үр дүн, үр нэлөө:

- Захидал Уриалгын Марафоноор хүний эрх, эрх чөлөөг хамгаалахыг уриалсан захидлуудад нийт 13 000 гаруй гарын үсэг цуглуулж Филиппин, АНУ, Өмнөд Африк, Энэтхэг, Узбекистан, Норвеги, Арабын Нэгдсэн Эмират, Хятадын эрх баригч нарт илгээв.
- Үйл ажиллагаанд нийт 3910 хувь хүн, идэвхитэн тэмцэгч нар оролцов.



ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ



Зорилго, зорилтууд:

- Монгол улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлах, үр нөлөө бүхий үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулахад нөлөөлөх;
- Эрүүдэн шүүхийн бүх хэлбэр болон бусад зүй бус харьцааг хориглохыг шаардах;
- Улс орондоо явуулж буй ажлыг дэлхий нийтийн зорилтуудтай нийцүүлэн явуулах

Нөлөөлөл

- Эрүүдэн шүүх гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах тогтолцоог алга болгосон УЕПДМБА-ыг татан буулгах тухай УИХ-ын 22-р тогтоолыг эсэргүүцэж, энэ асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран УИХ-ын даргад асуулга хүргүүлж, хувийг УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгийн хороо, УЕПГ, ХЗЯ-нд тус тус хүргүүллээ.
- “Эмнести Интернэшнл Монгол улсыг шударгаар шүүхийг шаардаж байна” олон нийтийн мэдэгдлийг МУ-ын ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Хууль зүйн сайд нарт хүргүүлэв. Түүнчлэн Хууль зүйн сайдад Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 4.6-р зүйл ял завших боломж бурдүүлж байгаад анхаарал хандуулж, өөрчлөхийг, мөн гадаадын иргэдийг хүчээр албадан гаргаж байгаад анхаарал хандуулахыг хүссэн албан захиалыг тус тус илгээн, хариуг авлаа.

- 12-р сарын 10 буюу Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилт Монгол улсад” онол практикийн бага хурлыг ХЭҮК-той хамтран зохион байгуулж, хууль сахиулах

байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Олон улсын кампанит ажил

- Эмнести Интернэшнлээс 2014 оны 5-р сарын 13-нд “ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ” даян дэлхийн кампанит ажлыг дахин эхлүүлж, хэвлэлийн бага хурал хийлээ. 50 жилийн өмнө Эмнести Интернэшнлээс эрүүдэн шүүхтэй тэмцэх дэлхий дахины кампанит ажлыг өрнүүлсэн ба үүний үр дүнд НҮБ-аас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийг баталсан юм. Өнөөдөр 156 улс орон энэ конвенцийг соёрхон баталсан ч өнгөрсөн таван жилийн хугацаанд 141 улсад эрүү шүүлт, зүй бус харьцаа байгааг тайландaa дурдсан. Эмнести Интернэшнл зарим улсад эрүү шүүлтийн цөөн, онцгой тохиолдлыг бүртгэсэн бол бусад улсад эрүү шүүлт байнга, системтэй үйлдэгддэг болохыг баримтжуулсан.





■ Уг кампанит ажлын хүрээнд бид Филиппин, Узбекистан улсад үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө, мөн хилсээр хэрэг хүлээж эрүүдэн шүүгдсэн хувь хүмүүсийн хэрэг дээр гарын үсэг цуглуулах үйл ажиллагааг их дээд сургуулиуд дээр зохион байгууллаа.

Хэвлэл, мэдээлэл, соён гэгээрүүлэх

- Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаар хэвлэл мэдээллээр олон нийтэд хүргэх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд vip76.mn сайттай хамтран 11-р сарын 10-наас 12-р сарын 10-ны хооронд “Эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгах хараат бус тогтолцоо Монголд байна уу” сэдвээр нийгмийн сүлжээнд хэлэлцүүлэг өрнүүллээ.
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Монголын Мэдээ сонинтой хамтран цуврал мэдээ материалыг олон нийтэд хүргэлээ. Хүний эрх, ялангуяа халдашгүй байх эрхийг олон нийтэд таниулах үйл ажиллагаанд залуучууд идэвхийлэн манлайлж, Роуал ТВ-ийн цуврал нэвтрүүлэгт оролцов.
- Хүний Эрхийн ТББ-удын сүлжээний хэвлэл мэдээллийн зах арга хэмжээ, Цэцэрлэгт хүрээлэнд “Футболкны өдөр” буюу 20 жилийн ойд зориулсан арга хэмжээ, 6-р сарын 26 буюу Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрөөр Тусгаар тогтолын талбайд болон Албадан саатуулах байранд хоригдож буй хүмүүст ХЭҮК-той хамтран яриа, таниула, кино хэлэлцүүлэг, “Нээлттэй өдөр” залуусын дуу хоолойг хүргэх үйл ажиллагаа зохион байгууллаа.



Амжилт, үр дүн, үр нөлөө

- Монгол улс Хүчээр сураггүй алга болгохын эсрэг Конвенци болон Эрүүдэн Шүүхийн эсрэг Конвенцийн нэмэлт протоколд нэгдэн оров.
- Эрүүдэн шүүхийн асуудлаарх үйл ажиллагаанд онлайн болон биечлэн нийт 10360 идэвхитэн дэмжигч оролцож дуу хоолой, хувь нэмрээ оруулав.
- Монгол улсад эрүүдэн шүүх гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах тогтолцоо бүрдүүлэхийг шаардаж буй хувь хүн иргэд, иргэний нийгмийн байгууллага, идэвхитнуудийн тоо нэмэгдэв.
- Шударгаар шүүлгэх эрхийн асуудал олон нийтийн болон олон улсын анхаарлын төвд оров.



ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ



Зорилго, зорилтууд:

- Гишүүд дэмжигчид, олон нийтэд сургалт, хэлэлцүүлэг хийн чадавхижуулах
- Хүний эрхэд ээлтэй сургууль төслийн сургуулиудыг дэмжих, төслийг түгээн дэлгэрүүлэх
- Малчид, иргэний нийгмийн байгууллагыг чадавхижуулах
- Төрөл бүрийн салбарт түншлэл тогтоох, тэднийг хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд татан оруулах



Иргэдэд хүний эрхийн сургалт явуулж, эрхээ хамгаалах чадвартай болго

- Завхан, Хөвсгөл аймгийн малчид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 60 хүнд хүний эрхийн сургалт хийж, эрхээ хамгаалах, шаардах, хамтран кампанит ажил өрнүүлэх тухай мэдлэг олгож, төгсөгчид сурсан мэдлэгээ аймагтаа түгээн олон улсын хүний эрхийн өдрөөр бэлэг барилаа.
- Ахмадын эрхийг хамгаалах өдрөөр нийслэлийн ахмад, өндөр настан 200 гаруй хүнд хүний эрхийн тухай сургалт, ярилцлага хийн санал бодлыг нь сонсов. Чилийн Хүний эрхийн цахим сургалтад 30 гишүүн хамруулж, сургалтын бааз бэлтгэж эхлэв.

■ Хүний эрхийн уран бүтээлийн уралдаанд 50 гаруй бүтээл, Нэгж хичээлд хүний эрхийг нэгтгэн нээлттэй хичээл заах ур чадварын уралдаанд 12 багш, Олон улсын хүний эрхийн өдрөөр үйл ажиллагаа өрнүүлэх кампанит ажлын 4 төсөл ирүүлснийг шалгаруулж, мэдээлэл бэлтгэн Монголын мэдээ сонинд нийтэлж, mminfo.mn, МЭИ-ийн вэб хуудас болон Фэйсбуукт тавьж олон нийтэд хүргэлээ.

■ Хобби, Хүрээ тулга дунд сургуульд "Хүний эрхэд ээлтэй сургууль төсөл"-ийн хоёр дахь шатны сургалтыг сургуулийн удирдах ажилтан, багш, ажиллагсдын төлөөлөл тус тус 30 хүн, нийт 60 хүнийг хамруулав. Хүний эрхэд ээлтэй сургууль төслийн нэгдүгээр шатны дүгнэлт, хоёрдугаар шатны

төлөвлөлтийг хэлэлцэх уулзалт Энэтхэгийн Дели хотноо болж, Эмнести Интернэшнлийн ХЭЭС төслийн үйл ажиллагаа, амжилт, алдааг хэлэлцэн цаашид ХЭЭС төслийг хөгжүүлэх, дэмжих талаар

улс орон болон олон улсын туршлагыг судлуулсан ажил хэрэгч уулзалт болов. Монголын Эмнести Интернэшнл уг хуралд өөрийн туршлагаас хуваалцахын зэрэгцээ ХЭЭС төсөлд нэгдсэн сургуулиудаа дэмжиж, урамшуулан, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллах нь бусад сургуулийг эгнээндээ нэгтгэн өсвөр үеийг хүний эрхийг ойлгодог, хүндэлдэг, сургуулийг хүний эрхэд ээлтэй болгох чухал ач холбогдолтой болохыг дүгнэсэн байна.



Хүний эрхийн боловсролын нөлөөллийн ажил

- МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимтэй хамтран Монгол улсын их, дээд сургуулийн философиийн мэргэжлийн бус ангийн оюутнуудад "Философи хүний эрхийн уулзварт" философиийн 5-р олимпиад, "Хүний эрхийн асуудлаарх философиийн халз тулаан"-ыг их, дээд сургуулийн дунд уламжлал болгон МУБИС, МУИС-ийн философи мэргэжлийн ангийн оюутны дунд тус зохион байгуулав.

- "Эрхээ мэдье" хүний эрхийн асуудлаарх Парламентын мэтгэлцээнийг 2 үе шаттай зохион байгуулж, 2014 оны аварга багийг тодруулав. Мэтгэлцээнд зориулан Парламентын мэтгэлцээний дүрэм журмыг тайлбарласан үзүүлэх тоглолт бүхий сургалтын видео кино бүтээж, МЭИ-ийн вэв хуудас



болон Фэйсбуукаар дамжуулан олон түмэнд түгээнээр ЕБС-ийн сурагчдын сонирхол нэмэгдэн хэд хэдэн сургуульд Парламентын мэтгэлцээний дугуйлан нээгдэв. Нийслэлийн Боловсролын газар, Отгонтэнгэр их сургууль хамтран зохион байгуулж, Ай Ти Зоун Компьютерийн их дэлгүүрийн Могул брэнд, Номин Электроникс Монел брэнд болон Хобби сургууль дэмжиж ажиллалаа.



Амжилт, үр дүн, үр нөлөө:

- Завхан, Хөвсгөл аймгийн малчин болон иргэний нийгмийн төлөөлөл 60 хүн эрхээ хамгаалж үйл ажиллагаа өрнүүлж чадах болов.
- ЕБС-ийн сурагчдын дунд Парламентын мэтгэлцээнийг уламжлал болгон зохион байгуулснаар оролцогчдын тоо нэмэгдэж, Нийслэлийн 9 дүүрэг, Дархан-Уул, Орхон аймгийн 98 баг өрсөлдөж, хүний эрхийн мэдлэгээ сорьж мэтгэлцлээ.
- Хүний эрхийн уралдаан, тэмцээний үрээр ХЭЭС төслийг сонирхох сургуулиуд нэмэгдэв.
- Үйл ажиллагааг цахимаар 7700 идэвхитэн дэмжлээ.



БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ - ЗАЛУУЧУУД ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ



Зорилго, зорилтууд:

- Бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, идэвхтнүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах, үйл ажиллагааг дэмждэг сайн дурын ажилтнуудыг тоог нэмэгдүүлэх

Үдирдлага, манлайлал, байгууллагын чадавхи

- Удирдах Зөвлөл ээлжит 6 удаа, ээлжит бус 2 удаа хуралдаж, нийт 28 шийдвэр гаргаснаас 3 шийдвэр хэрэгжих шатандаа, бусад нь биелэсэн. Хяналтын зөвлөл 3 удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажиллаа.
- Манлайлагч нар “Удирдлагын менежмент”, “Манлайлал,” “Онлайнаар хурал уулзалт зохион байгуулах нь”, “Сан арвижуулах арга тактик” сургалтанд хамрагдлаа.
- Олон улсын үнэлгээний багийн гишүүд Монголд зочилж хамтран ажилладаг байгууллага, гишүүд, дэмжигчид, хувь хүмүүстэй уулзан үнэлгээ хийсний дагуу Монголын Эмнести Интернэшнлийг олон улс, үндэсний, бус нутгийн хүний эрхийн асуудлаар илүү өргөн хүрээнд ажиллах “Секцийн статус” эрхийг олгов.
- 2016-2019 онд нэн тэргүүнд анхаарч ажиллах Хүний эрхийн асуудлаархи Олон улсын стратегийн хэлэлцүүлгийг хоёр үе шаттайгаар онлайн болон оффлайн хэлбэрээр зохион байгуулж хамтран ажилладаг байгууллага, эрдэмтэн, судлаач, гишүүд дэмжигчдийнхээ саналыг багцлан авч тусгалаа. Хэлэлцүүлэг, судалгаа нийт 45584 идэвхитэн дэмжигч, гишүүд, хамтрагч, эрх эдлэгчдийг хамарсан байна.

Бүлэг, гишүүдийг өргөжүүлэх, чадавхжуулах, идэвхжүүлэх чиглэлээр

- Цахим болон цахим бус сургалт, хэлэлцүүлэг, кампанит үйл ажиллагааны үеэр МЭИ-д 720 шинэ гишүүн, дэмжигч элсэв. Шинэ гишүүдийн болон кампанит ажлын чадавх бэхжүүлэх сургалт, чөлөөт ярилцлагыг 30 гаруй удаа зохион байгууллаа.
- Хүний эрхийн боловсрол, Цаазаар авах ялын эсрэг кампанит ажлын хүрээнд зохион байгуулагдсан сургалт, хэлэлцүүлгийн үеэр Завхан, Хөвсгөл, Төв аймагт албан бус бүлэг үүсч орон нутгийн бүлэг өргөжлөө.
- Байгууллагын тогтвортой байдал чадавх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор олон улсын болон орон нутгийн хэмжээний 20 гаруй хурал, семинар, чуулга уулзалт, сургалтуудад 60 орчим гишүүд дэмжигчид, ажилтнуудаа оролцууллаа.
- Бүлгийн болон бүлгийн ахлагчдын уулзалт, сургалт, хэлэлцүүлэг, чөлөөт ярилцлагыг 30 гаруй зохион байгуулж бүлгүүд кампанит ажилд хэрхэн оролцох, гишүүдээ идэвхжүүлэх





чадавахжуулах, гишүүд дэмжигчид хүний эрхийн асуудлаар санал бодлоо солилцлоо.

- Сан арвижуулах ажилд техник, технологийн дэвшилтэд хэрэглээг үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж, САТ /компьютерт сууринсан орчуулга сургалтыг бүх ажилтан, орчуулгын ажилд тусалдаг сайн дурынханд явуулав. Ингэснээр орчуулгын ажлыг хөнгөвчилөх, улмаар орчуулгын зардлыг хэмнэх боломж бүдүүлэх юм. Улмаар энэ сургалтыг авахыг хүссэн хувь хүн, байгууллагад төлбөртэй заан сан арвижуулалт хийлээ.
- Хаан Банкны Мобайл Пос төхөөрөмжийг өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэн ажиллав. Ингэснээр МЭИ төв байранд болон ЭИ-ээс зохион байгуулж буй үйл ажиллагааны үеэр хандив өргөх, гишүүдийн татвар төлөх ажиллагааг хөнгөвчлөөд байна.

Монголын Эмнести Интернэшнл үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой

- Монголын Эмнести Интернэшнл үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг тодорхой хөтөлбөрөөр зохион байгуулж 5-р сард “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” цахим фото альбом, Футболканы өдөрлөг, 12-р сард “Хүний эрхийн төлөө бахархам түүх” цахим ном туурвин, “Бид мартаагүй” баярын арга хэмжээг тус тус зохион байгуулж гишүүд, идэвхитэн дэмжигч, хамтрагч нараа оролцуулан өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүллээ.
- Хүний эрхийг хамгаалах, үйлсэд хувь нэмрээ оруулсан 5 гишүүн “Хүнийг эрхийн төлөө тэмцэгч” цом, 14 гишүүн, хамтран ажилладаг байгууллагын төлөөлөл 2 хүн “Хүний эрхийн төлөө тэмцэгч” өргөмжлөл, 1994- 2013 он хүртэл сонгогдон ажилласан Удирдах зөвлөлийн дарга, дэд дарга, Хяналтын зөвлөлийн дарга нарт хүндэтгэн үзүүлэн “Бид мартаагүй” дурсамж, 11 шилдэг сайн дурын ажилтан

“Хүний эрхийн төлөө-Хамгийн хамгийн” шагнал авлаа.

- Хүний эрхийг хамгаалах үйлсэд үнэт цаг, зүрх сэтгэлээ зориулсан “хүний эрхийн хамгаалагчдын бахархам түүх” цахим ном бүтээж цахим хуудсанд байршууллаа.
- Хүний эрхийн асуудлыг зөрчлийг илрүүлэн, таслан зогсоох иргэдийн чөлөөт индэр болох “Хүний эрхийн нүд” үндэсний мэдээллийн марафоныг орон даяар зарлан Улаанбаатар хот болон 21 аймгаас иргэдийн мэдээллийг amnesty.mn вэб сайтаар дамжуулан авч байна.

Амжилт, үр дүн үр нөлөө

- Монголын Эмнести Интернэшнл секцийн статустай болов.
- МЭИ-ийн цахим хуудсаар 2014 онд нийт 166818 хүн зочилж мэдээ, мэдээлэл авлаа.
- Хүний эрхийн төлөөх цахим болон цахим бус үйл ажиллагаанд нийт 148,037 идэвхитэн, дэмжигч оролцов.
- 2014 онд нийт 88 үйл ажиллагааг оффлайн хэлбэрээр 143 үйл ажиллагааг онлайн хэлбэрээр зохион байгуулав.
- 20 жилийн ойд зориулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх футболканы өдрийг 3 хот, 2 аймагт нэгэн зэрэг тэмдэглэж, нийт 4000 гаруй идэвхитэн дэмжигч онлайнаар эв нэгдлээ илэрхийлж оролцоо гадна, жил бүр уламжлал болгон зохиож байх хүсэлт МЭИ-д ирсээр байна.

ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД

БАЙГУУЛЛАГА АЖ АХҮЙН НЭГЖ

- Арвай Бурхан принт
- Архангай Багшийн их сургууль
- Багануурын иргэний нийгмийн сүлжээ
- Батбайгаль ХХК
- Дархан Од цогцолбор сургууль
- Дэйл Карнеги
- Иргэдийн Альянс төв
- Иргэд цагдаа хамтын ажиллагааны төв
- Монголын мэдээ сонин
- МОНЭС ТББ
- Могул бренд
- Монел бренд
- МУИС Шинжлэх ухааны их сургууль
- Нийслэлийн соёл урлагийн газар
- Нийслэлийн биеийн тамир спортын газар
- Нийслэл аудит
- Нээлттэй нийгэм форум
- ОУ-ын сургууль

- Санхүүгийн тооцоолох ХХК
- Төв аймгийн ЗДТГ-ын Хуулийн хэлтэс
- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн
- Хобби дунд сургууль
- Хос важра ХХК
- Хөвсгөл аймгийн иргэний нийгмийн байгууллага
- Хөх гацуурхан театр
- Хууль зүйн үндэсний хүрээлэн
- Хүний эрхийн үндэсний комисс
- Шинжлэх ухааны академи
- Эрдэнэт өртөө
- Эрдэнэт Эрдэм ахлах сургууль
- IT ZONE
- Royal HD телевиз
- VIP 76



ХУВЬ ХҮМҮҮС

• Ж.Амарсанаа	• С. Ганчимэг	• Д.Оюун	• Т.Хулан
• Р. Алзахгүй	• Х.Даваахүү	• Р.Оюунбадам	• У.Цогзолмаа
• Б.Алтангэрэл	• Л.Дашдэмбэрэл	• Б.Оюунчимэг	• Д.Цэвэлмаа
• Б. Ариунаа	• Т. Дөлгөөн	• Л.Пүрэвжаргал	• Г.Цэвэлмаа
• Э. Анударь	• М.Дуламжав	• М.Пүрэвжүгдэр	• Б.Цэнд-Аюуш
• Г. Ариунболор	• Ч. Жадамба	• Г.Пүрэвдорж	• Б.Цэрэндуулам
• Д. Бадамцэцг	• Г.Жамъян	• Т.Рагчаасүрэн	• З.Цэрэндуулам
• В.Базарваань	• М. Жаргалант	• Х.Саранчимэг	• Г.Цэцэгээ
• Ж.Болор	• В.Золжаргал	• Б.Туяжаргал	• А.Шинэтэгс
• М.Болор-Эрдэнэ	• Б.Норжмаа	• А.Түвшинтулга	• Ц.Эрдэнэбат
• А.Булгамаа	• Ц.Отгонжаргал	• С.Урангоо	• Л.Эрдэнэчимэг
• Л. Гантөмөр	• Э.Отгончулуун	• Ё.Уганбаяр	• Ц.Эрхэмбаяр
• С.Нарангэрэл			

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2014 оны санхүүгийн хураангуй тайлан

(USD)

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ			
		2014 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31	2014 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31
		Төсөв	Бодит
Санхүүжилт			
Сан арвижуулах үйл ажиллагааны орлого	141,267	28,190	
Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт	151,579	151,579	
Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт-Азийн хэлний хөтөлбөр	8,156	8,156	
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	301,002	187,925	
Зарцуулалт			
Сан арвижуулах үйл ажиллагааны зардал	17,335	14,091	
Хурал, уулзалтын зардал	10,949	9,662	
Цалин хэлс	76,435	74,778	
Оффисын зардал	45,628	43,516	
Компанит ажил, төсөл хөтөлбөр ба сургалт	147,701	50,280	
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	2,954	6,910	
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	301,002	199,236	
Эхний улдэгдэл			
Бэлэн мөнгө [касс ба банкин дах]	38,909.77		
Нөөц сан	40,494.42		
Авлага	834.07		
Өглөг	1,977.89		
Эцсийн улдэгдэл			
Бэлэн мөнгө [касс ба банкин дах]		3,620.21	
Нөөц сан		51,535.52	
Авлага		13,450.04	
Өглөг		1,656.33	




Д.Ариунбулган
Б. Алтантуяа

Ч.Гүнбаатар /"Сүлд аудит" ХХК/

2014 оны санхүүжилт Income 2014


187,925.18



2014 оны зарцуулалт

Expenditure 2014

(Нийт 199,236.11ам.доллар)



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНИЙН 20 ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ТОВЧООН

- Лондон дахь ОУНБДНГ, Америкийн ЭИ-ээс төлөлөгчид Монголд ирж хүний эрхийн сургалт явуулахын сацуу, хүний эрхийн зүтгэлтнүүдтэй уулзаж анхны албан бус бүлгүүд байгуулагдав.
- Оюутан залуу, Багш, Хуульч, Эмэгтэйчүүд гээд нийгмийн идэвхитэй гишүүд нэгдэж эхлэв
- “Монгол улсад хоригдлууд өлбөрч үхэж байна” **Индекс ASA30/02/95** дугаар бүхий илтгэлийг 1995 оны 4 сард Олон улсын Эмнести Интернэшил байгууллагаас гаргаж, дэлхий дахинд мэдээлэв.

- ХЭТТ батлагдсаны 50 жилийн ойг өргөн хүрээнд тэмдэглэж радио, телевизээр хүний эрхийн сургалтуудыг орон даяар явуулав
- Дэлхийн том ном аянд оролцож Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Ц.Элбэгдорж болон цагдаа, цэрэг, оюутан залуус, багш, хөдөө орон нутаг дахь малчид, иргэд гээд 200,000 гаруй хүнээс хүний эрхийг хамгаалахад хувь нэмэрээ оруулна гэсэн амлалтыг авав.
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид Монгол улсыг нэгдэж оруулах, эрүүдэн шүүхтэй тэмцэх кампанит ажлаа эхлүүлэв.
- Хүний эрхийг заахтай холбогдсон гарын авлага ном товхимолыг олноор гаргаж, Хүний эрхийн анхны сургач багш нарыг бэлтгэв.



**1994
1995**

**1996
1997**

**1998
2000**

**2001
2004**

**2004
2008**



- Оюутан залуус, Багш нар, Хуульчдын бүлэг нэгдэж Эмнести Интернэшилийн Монголын Үндэсний Зохицуулах хороо байгуулагдан албан ёсоор бүртгүүлэв.
- Өвөр монгол иргэд, Улс төрийн хэрэгт хэлмэгсдийн, Орчуулагч, Христэд итгэгчид, Сэлэнгэ, Багануурын бүлэг гэх мэтээр гишүүд, бүлгийн тоо өргөжин тэлэв.
- Цаазаар авах ялыг халуулах, дүрвэгсдийн эрхийг хамгаалах, үзэл санааны хоригдлыг суллуулах, Оюутан залууст хүний эрхийн мэдлэг олгох ажлуудыг өргөнөөр зохион байгуулж байв.
- Байнгын ажиллагаатай Олон Улсын Эрүүгийн Шүүх, Үндэсний хүний эрхийн байгууллага байгуулахыг дэмжин, кампанит ажлаа эхлүүлэв
- “The wire” сонин тогтмол гардаг болж, ХЗЯ-наас гэрчилгээгээ авав.

- Олон улсын эрүүгийн шүүх байгуулагдсан бөгөөд Монгол улс Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нэгдэж орсон 60 дахь улс болов.
- Үндэсний хүний эрхийн байгууллага болох Хүний эрхийн үндэсний комиссийн байгуулагдас. Монголын Эмнести Интернэшил комиссиин дэргэдэх албан бус зөвлөлийн гишүүн болов.
- Монгол улс Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенц-д нэгдэн орсноор эрүүдэн шүүх явдлыг гэмт хэрэг гэж үзэн хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт өргөн хүрээнд зохион байгуулагдав.
- Хүний эрхийн боловсрол ерөнхий боловсролын сургуулиудад төдийгүй их дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулах их аян өрнөв.
- Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг кампанит ажлыг эхлүүлэв.



- Парламент, Дархан, Эрдэнэт, Эмч, Эмэгтэйчүүд, Эрэгтэйчүүд, Чөлөөт гэх мэтээр гишүүд бүлгийн тоо өргөжин 1000 гаруй гишүүнтэй байгууллага болон өргөжив.
- Хүч ба галт зэвсэг хэрэглэх цагдаагийн үйл ажиллагааны гарын авлага, Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь, Эрүүдэн шүүхтэй тэмцэх аргачилал, Хүний эрхийн боловсрол олгох багшид зориулсан ном товхимлуудыг гаргаж, сургалт явуулан хүний эрхийн боловсрол олгох албан бус тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулав.
- ХЭТТ-ын 60 жилийн ойг тэмдэглэх их аяныг өрнүүлж Дэлхийн иргэний паспортыг гаргав
- Хүний эрхийг хамгаалах үйлсэд залуусыг татан оролцуулах Залуучуудын стратегийг боловсруулан гаргаж, “Эрхийнхээ төлөө шуугицгаа” задгай тогтолтыг жил бүр зохион явуулдаг болов. Энэ ажиллагааг дэмжсэн залуучууд Эрхийнхээ төлөө гарaa өргөцгөө аян өрнүүлж задгай тогтол “Эрх чөлөөний парад” болон өргөжив.
- Монголын Эмнести Интернэшил бүтцийн эрхээ албан ёсоор баталгаажуулав.
- ОУНБДНГ-ын хүний эрхийн шинжээч Монгол улсад айлчлав.
- Зэвсэгийн худалдааны гэрээтэй болохыг дэмжсэн “Зэвсэгийн хяналт” кампанит ажлаа эхлүүлэв.

- The Wire сонин бичиг 2 сар тутмын сэтгүүл болов. Сэтгүүлд Livewire блог нэмж оров.
- Монгол улсыг Эрүүдэн Шүүхийн Эсрэг Нэмэлт Протокол-д нэгдэн оруулах, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй механизм байгуулах талаар аян өрнүүлэв.
- Монгол улсын шинэ Эрүүгийн Хуулийн төсөлд санал, зөвлөмж хүргүүлэв.
- Эдийн засаг нийгэм соёлын эрхийг хамгаалах "Хүнийг хүндэл" кампанит ажлаа эхлүүлэв.

2009
2010



- ОУНБДНГ-ын хүний эрхийн шинжээч нар Монгол улсад 2 дахь удаагаа айлчлан Монгол улсын ерөнхийлөгчтэй уулzan, Дэнжийн 1000 дахь Албадан саатуулах төв болон Цагдан хорих төвөөр айлчлав.
- "Бид эндээс хаачих вэ" Монгол улсад, 2008 оны 7 дугаар сарын 1-нд болсон үйл явдлын сургамж нэртэй тайлан хэвлэгдэж, дэлхий дахинд цацагдас.
- Хорих байгууллагад мониторинг хийх чиглэлээр 15 гаруй ТББ-ын чадавхийг сайжруулах 5 хорин анги дээр мониторинг хийв.
- Монголын улсын ерөнхийлөгч цаазаар авах ялын түдгэлзүүлэх уриалга гаргаж, бүрэн эрхийнхээ хүрээнд цаазаар авах ялтай хориглуудад уучлал үзүүлэхээ амлалаа.
- НҮБ-ын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт Монгол улсын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх илтгэл хүргүүлэв.



2011
2012

- Монгол улсын ерөнхийлөгч Цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлэхийг уриалж, Монгол улс ИУТЭОУП-ийн 2-р Нэмэлт Протоколд нэгдэн оров.
- Эрүүдэн шүүхийн хохирогсод туслах өдрийг өргөнөөр тэмдэглэв.
- Залуучууд "ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ" хүний эрхийг заах сургалтын гарын авлагатай болов.
- Эмнэсти Интернэшнлийн 50 жилийн ойг Дархан, Эрдэнэт, Багануур, Улаанбаатар, Архангай зэрэг 5 газарт нэгэн зэрэг буухиалан тэмддэглэв.
- Хүний эрхэд ээлтэй сургууль төсөлд Дархан Уул аймгийн Од цогцолбор, Эрдэнэтийн Баян Өндөр Цогцолбор, Дарханы 19-р сургууль нэгдэв.
- Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас Хөдөлгөөний хөгжил хариуцсан тэргүүн захирал Колм О.Кунакайн айлчлал хийж, Монгол улсад зохиогдож буй "Уул уурхай ба хүний эрх чуулган"-д оролцон ЭИ-ийн туршилага, байр суурийг танилцуулж, УИХ-ын дэд даргатай уулзалт хийн "2012-2015 онд ажиллас УИХ-д санал болгох хүний эрхийн хэлэлцэх асуудлыг өргөн барив.
- Цахим хуудас жилдээ ойролцоогоор 34000 хүн зочилж мэдээлэл авдаг болтлоо өргөжив.

2013
2014

- Охид, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг хамгаалах "Миний бие Миний эрх" аянаа эхлүүлэв.
- НҮБ-ын Ерөнхий ассамблейгаар "Зэвсэгийн худалдааны талаарх гэрээ" батлагдаж, Монгол улс гарын үсэг зурав.
- Шударгаар шүүлгэх эрх гарын авлагыг хэвлэн гаргаж, өргөнөөр түгээв. Олон улсын төвөөс Монгол улсыг шударгаара шүүхийг уриалсан мэдэгдэл гаргав.
- Хоригдогдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял өдлүүлэх ажиллагаан стандартад санал зөвлөмж хүргүүлэв.
- "Хүний эрх боловсролын тогтолцоонд" онол практикийн бага хурлыг ХЭҮК, МУИС-ын ХЭС, НБГ-тай хамтран зохион байгуулав.
- Монгол улс "Хүчээр сураггүй алга болгохос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц"-д нэгдэв.
- Хүний эрхэд ээлтэй сургуулиудад олон улын төвөөс үнэлгээ хийв.
- Хүний эрхийн сургагч багш бэлтгэх аяа өрнүүлж 600 гаруй оюутан залуу, багш, цагдаагийн алба хаагчдыг бэлтгэв.
- "Эрүүдэн шүүхийн хяналт ба Монгол улс", "Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилт Монгол улсад" зэрэг олон улсын семинар, хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулав.
- Монгол улс эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколд гарын үсэг зурж, соёрхон батлав.
- Газар чөлөөлөхтэй холбоотой асуудалт анхаарал хандуулж, хуулийн төслүүдэд холбогдох санал зөвлөмжийг хүргүүлэв. "Үүргээ мэд" гарын авлагыг төрийн албан хаагчдад, "энэ бол таны гэр орон, орон байртай байх таны эрх" хяналтын хуудсыг 5000 хувь хэвлэж, тараав.



ИЙГ
ІДЭЛ



ЭРҮҮДЭН ШУУХИЙ ЗОГСОӨ



Э



ХҮНИЙГ
ХҮНДЭЛ




ЭРҮҮДЭН ШУУХИЙ ЗОГСОӨ



ХҮНИЙГ
ХҮНДЭЛ



ЭРҮҮДЭН ШУУХИЙ ЗОГСОӨ



ХҮНИЙГ
ХҮНДЭЛ



ЭРҮҮДЭН ШУУХИЙ



ЭГЛЭЛИЙГ ХЯНАЯ



ЗЭВСЭГЛЭЛИЙГ ХЯНАЯ



ХҮНИЙГ
ХҮНДЭЛ




ХҮНИЙГ
ХҮНДЭЛ





2014 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ



Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, Бага тойруу - 44
Утас/факс: 976-11-324705
Цахим хаяг: aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

